

СЭЛЭНГЭ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Сэлэнгэ аймгийн Сүхбаатар сумын Эмнэх-баг өрхийн эрүүл мэндийн төвийн 2023 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

Аудитын код: СЭА-2024/66-НА-СТА-ТШЗ

Цахим хуудас: www.selenge@audit.gov.mn	Дарга, тэргүүлэх аудитор: Ч.Энхтуяа
Сүхбаатар сум	Утас: 7036-3040 Цахим хаяг: enkhtuyach@audit.gov.mn
2024 он	Аудитын менежер: Б.Батмөнх
	Утас: 7036-3036 Цахим хаяг: batmunkhb@audit.gov.mn
	Аудитор: Д.Чулуунцэцэг
	Утас: 7036-2442 Цахим хаяг: Chuluuntsetsegd@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

Агуулга

1. Аудитын дүгнэлт	3-4
2. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл	5
3. Санхүүгийн тайлангийн тодруулга	6-12
3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа	13
3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин	13
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал	14
3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлт	14
3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв	14
4. Аудитын тайлан	15
4.1 Ерөнхий зүйл	15
4.2 Материаллаг байдал	15
4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт	16
4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал	16
4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт	16
4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал	16
5. Аудитын илрүүлэлт	17
6. Аудитаар илэрсэн буруу илэрхийллийн нэгтгэл	18

Товчилсон үгийн жагсаалт

АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
ЗД	Засаг дарга
НДШ	Нийгмийн даатгалын шимтгэл
ХХК	Хязгаарлагдмал хувьцаат компани
ШШГГ	Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газар
ЭМДС	Эрүүл мэндийн даатгалын сан
ЭМДҮЗ	Эрүүл мэндийн даатгалын үндэсний зөвлөл
ЭМГ	Эрүүл мэндийн газар
ЭМЯ	Эрүүл мэндийн яам



СЭЛЭНГЭ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

II баг, Цагаан эрэг, Сүхбаатар сум,
Сэлэнгэ аймаг, 43081
Утас/Факс: (976)-7036-3040
Цахим шуудан: Selenge@audit.gov.mn
Цахим хуудас: www.audit.mn

СҮХБААТАР СУМЫН ЭМНЭХ- БАГ
ӨРХИЙН ЭРҮҮЛ МЭНДИЙН ТӨВИЙН
ДАРГА Ц.ЦЭЦЭГСАЙХАН ТАНАА

2024.02.23 № СЖА-2024/66-НА-САН-ТНЗ
танай _____-ны № _____-т

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Сэлэнгэ аймгийн Сүхбаатар сумын Эмнэх-баг өрхийн эрүүл мэндийн төвийн 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Сэлэнгэ аймгийн Сүхбаатар сумын Эмнэх-баг өрхийн эрүүл мэндийн төвийн 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцолсон хэсэг

Тайлант онд шинээр иргэдэд үзүүлэхээр зөвшөөрөгдсөн 4 төрлийн тусламж үйлчилгээнээс сэргээн засах, өдрийн эмчилгээ, гэрийн тусламж зэрэг 3 төрлийн тусламж үйлчилгээг үзүүлэн 10,850.0 мянган төгрөгийн санхүүжилтийг төвлөрүүлсэн байна.

Аудитын гол асуудал

ӨЭМТ нь эрүүл мэндийн даатгалын сангаас гүйцэтгэлээр санхүүжиж “Бүх гишүүд нь бүрэн хариуцлагатай нөхөрлөл” гэсэн хариуцлагын хэлбэртэйгээр хүн

амд эрүүл мэндийн анхан шатны цогц тусламж, үйлчилгээг үзүүлэх зорилготой үйл ажиллагаа явуулж байгаа бөгөөд санхүүгийн тайлан нь төсвийн төвлөрүүлэн болон ерөнхийлөн захирагчийн санхүүгийн тайланд нэгтгэгдэж, тайлагнагдах зохицуулалтгүй байна.

Бусад асуудлын хэсэг

Сэлэнгэ аймаг дахь ЭМДХ нь тус байгууллагтай байгуулсан “Эрүүл мэндийн анхан шатны тусламж үйлчилгээг худалдан авах гэрээ”-г ЭМДҮЗ-ийн 07 дугаар тогтоолд заасан гүйцэтгэлийн шалгуур үзүүлэлтээр дүгнэж “Маш сайн” буюу 95.3 хувьтай үнэлсэн байна.

Эрүүл мэндийн сайдын 2022 оны 02 сарын 22-ны өдрийн А/104 дугаар тушаалаар батлагдсан “Журам, гэрээний загвар шалгуур үзүүлэлт батлах тухай” журмын дагуу аймгийн Засаг дарга болон Эрүүл мэндийн газрын дарга нь ӨЭМТ-ийн даргатай гэрээ байгуулж, санхүү болон үйл ажиллагаанд хяналт тавиагүй байна.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.


Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ч.ЭНХТУЯА

2. АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	59,652,674.67	55,557,154.20
31	МӨНГӨ БА ТҮҮНТЭЙ АДИЛТГАХ ХӨРӨНГӨ	6,737,143.90	4,179,458.26
312	Банкинд байгаа бэлэн мөнгө	6,737,143.90	4,179,458.26
3121	Төгрөг	6,737,143.90	4,179,458.26
31211	Төрийн сангийн харилцах	6,737,143.90	4,179,458.26
33	АВЛАГА	-	12,649,755.00
33300	Татаас санхүүжилтийн авлага	-	12,649,755.00
35	БАРАА МАТЕРИАЛ	52,915,530.77	38,727,940.94
351	Түүхий эд материал	25,320,748.77	22,791,018.94
35110	Тусгай зориулалттай материал	23,598,494.87	18,436,951.18
35130	Эм боох материал	1,722,253.90	4,354,067.76
354	Хангамжийн материал	27,594,782.00	15,936,922.00
35410	Бичиг хэргийн материал	398,940.00	350,280.00
35420	Аж ахуйн материал	26,925,842.00	15,456,642.00
35440	Түлш шатах тослох материал	270,000.00	130,000.00
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	100,868,178.03	90,153,630.73
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	100,868,178.03	90,153,630.73
392	Биет хөрөнгө	87,128,178.03	76,413,630.73
39201	Барилга, байгууламж	13,156,134.64	13,156,134.64
39202	Хуримтлагдсан элэгдэл	(3,427,170.72)	(4,778,963.40)
39203	Авто тээврийн хэрэгсэл	34,047,525.00	25,500,000.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	(23,047,525.08)	(17,250,000.12)
39205	Машин, тоног төхөөрөмж	136,885,910.11	100,867,561.17
39206	Хуримтлагдсан элэгдэл	(77,935,124.42)	(47,839,169.47)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	18,551,051.21	9,830,270.00
39208	Хуримтлагдсан элэгдэл	(11,102,622.71)	(3,072,202.09)
393	Биет бус хөрөнгө	13,740,000.00	13,740,000.00
39301	Программ хангамж	225,000.00	-
39302	Хасагдуулга	(225,000.00)	-
39303	Бусад биет бус хөрөнгө	13,740,000.00	13,740,000.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН	160,520,852.70	145,710,784.93
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ/ӨМЧИЙН ДҮН	160,520,852.70	145,710,784.93
51	Засгийн газрын хувь оролцоо	160,520,852.70	145,710,784.93
511	Засгийн газрын оруулсан капитал /ЗГСан/ орон нутгийн сан	24,948,500.00	24,948,500.00
51101	Өмч: -Төрийн өмч	24,948,500.00	24,948,500.00
512	Хуримтлагдсан үр дүн	127,386,412.70	115,669,895.93
51210	Өмнөх үеийн үр дүн	127,386,412.70	130,479,963.70
51220	Тайлант үеийн үр дүн	-	(14,810,067.77)
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	8,185,940.00	5,092,389.00
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ/ӨМЧИЙН ДҮН	160,520,852.70	145,710,784.93

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	715,889,521.06	523,980,334.67
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	26,982,606.16	14,134,433.19
120	Нийтлэг татварын бус орлого	26,982,606.16	14,134,433.19
120004	Төсөвт байгууллагын өөрийн орлого	26,982,606.16	14,134,433.19
120017	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого-ҮХ	11,942,663.29	13,134,500.40
120018	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого-БМ	15,039,942.87	999,932.79
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	688,906,914.90	509,845,901.48
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	448,996,629.90	-
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	448,996,629.90	-
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	236,890,285.00	-
131104	Дээд шатны төсвийн захирагчаас төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захи	236,890,285.00	-
1340	Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих	3,020,000.00	509,845,901.48
134001	Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих /урьдчилгаа 80 хувь/	2,010,000.00	486,346,146.48
134002	Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих /гүйцэтгэл 20 хувь/	1,010,000.00	23,499,755.00
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН (II)	735,009,868.29	538,790,402.44
21	УРСГАЛ ЗАРДАЛ	735,009,868.29	538,790,402.44
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	715,650,500.29	536,990,402.44
2101	Цалин, хөлс болон нэмэгдэл урамшил	435,893,972.00	375,476,201.00
210101	Цалин	435,893,972.00	375,476,201.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	39,413,158.00	46,608,689.89
210201	Тэтгэврийн даатгалын шимтгэл	27,130,881.00	32,038,744.89
210202	Тэтгэмжийн даатгалын шимтгэл	3,170,072.00	3,727,419.00
210203	ҮОМШ өвчний даатгалын шимтгэл	2,604,522.00	3,021,390.00
210204	Ажилгүйдлийн даатгалын шимтгэл	591,608.00	711,012.00
210205	Эрүүл мэндийн даатгалын хураамж	5,916,075.00	7,110,124.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	9,055,355.00	18,070,013.33
210301	Гэрэл цахилгааны зардал	1,486,053.00	8,466,055.33
210302	Түлш, халаалтын зардал	5,319,414.00	6,277,338.00
210303	Цэвэр, бохир усны зардал	2,249,888.00	3,326,620.00
2104	Хангамж, бараа материалын зардал	33,045,292.00	45,400,827.64
210401	Бичиг хэргийн материал	3,979,560.00	2,364,860.00
210402	Тээвэр, шатахууны зардал	4,066,600.00	2,663,000.00
210403	Шуудан холбоо интернетийн төлбөр	3,815,060.00	3,542,050.00
210405	Хог хаягдал устгах, цэвэрлэх	-	450,000.00
210406	Бага үнэ түргэн элэгдэл зүйлс	16,198,758.00	14,523,144.32
210407	Аж ахуйн материал худалдан авах зардал	71,000.00	-
210408	Бараа материал актасны зардал	4,914,314.00	21,857,773.32
2105	Нормативт зардал	122,549,232.59	19,877,589.88
210501	Эм	122,549,232.59	18,230,589.88
210502	Хоол	-	1,647,000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	7,082,500.00	2,503,000.00
210604	Урсгал засвар	7,082,500.00	2,503,000.00
2107	Томилот, зочны зардал	660,200.00	897,000.00
210702	Дотоод томилотын зардал	660,200.00	897,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр хураамж	4,349,226.00	3,783,033.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	4,349,226.00	3,634,533.00
210803	Даатгалын үйлчилгээний төлбөр	-	148,500.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	63,601,564.70	24,374,047.70
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	63,601,564.70	24,374,047.70
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	19,359,368.00	1,800,000.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	19,359,368.00	1,800,000.00
213209	Нэг удаагийн тэтгэмж шагнал урамшуулал	19,359,368.00	1,800,000.00
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III=I-II)	(19,120,347.23)	(14,810,067.77)
5	НИЙТ ҮР ДҮН (VII=III+VI)	(19,120,347.23)	(14,810,067.77)

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

	Үзүүлэлт	ГҮЙЦЭТГЭЛ	ГҮЙЦЭТГЭЛ
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН	688,906,914.90	497,196,146.48
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	688,906,914.90	497,196,146.48
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	448,996,629.90	-
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	448,996,629.90	-
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	236,890,285.00	-
131104	Дээд шатны төсвийн захирагчаас төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захи	236,890,285.00	-
1340	Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих	3,020,000.00	497,196,146.48
134001	Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих /урьдчилгаа 80 хувь/	2,010,000.00	486,346,146.48
134002	Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих /гүйцэтгэл 20 хувь/	1,010,000.00	10,850,000.00
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (II)	680,102,171.00	494,989,332.12
21	УРСГАЛ ЗАРДАЛ	680,102,171.00	494,989,332.12
210	БАРАА АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	657,742,803.00	491,779,332.12
2101	Цалин, хөлс болон нэмэгдэл урамшил	426,480,251.00	374,907,607.29
210101	Үндсэн цалин	426,480,251.00	374,907,607.29
2102	Ажил олгогчоос нийгтийн даатгалд төлөх шимтгэл	49,564,879.00	47,172,243.60
210201	Тэтгэврийн даатгалын шимтгэл	49,564,879.00	32,935,657.67
210202	Тэтгэмжийн даатгалын шимтгэл	-	4,640,936.40
210203	ҮОМШ өвчний даатгалын шимтгэл	-	2,784,490.07
210204	Ажилгүйдлийн даатгалын шимтгэл	-	810,438.35
210205	Эрүүл мэндийн даатгалын хураамж	-	6,000,721.11
2103	Байр ашиглалтай холбоотой тогтмол зардал	9,391,075.00	18,070,013.33
210301	Гэрэл цахилгааны зардал	1,486,053.00	8,466,055.33
210302	Түлш, халаалтын зардал	5,319,414.00	6,277,338.00
210303	Цэвэр, бохир усны зардал	2,585,608.00	3,326,620.00
2104	Хангамж, бараа материалын зардал	28,510,200.00	25,095,255.00
210401	Бичиг хэрэг	2,932,000.00	1,752,850.00
210402	Тээвэр, шатахуун	4,111,600.00	2,523,000.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	3,479,340.00	3,528,850.00
210404	Ном, хэвлэл	50,000.00	-
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	230,300.00	740,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	17,706,960.00	16,550,555.00
2105	Нормативт зардал	126,861,272.00	18,161,279.90
210501	Эм бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	119,345,672.00	14,756,279.90
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	7,515,600.00	3,405,000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	13,010,300.00	3,632,900.00
210601	Багаж техник хэрэгсэл	640,000.00	-
210603	Хөдөлмөр хамгааллийн хэрэгсэл	270,000.00	-
210604	Урсгал засвар	12,100,300.00	3,632,900.00
2107	Томилолт, зочны зардал	660,200.00	897,000.00
210702	Дотоод албан томилолт	660,200.00	897,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	3,264,626.00	3,843,033.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил, үйлчилгээний төлбөр хураамж	3,242,626.00	3,628,437.00
210803	Даатгалын үйлчилгээ	-	148,500.00

210804	Тээврийн хэрэгслийн татвар	-	32,346.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	22,000.00	8,000.00
210807	Газрын төлбөр	-	25,750.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	22,359,368.00	3,210,000.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	22,359,368.00	3,210,000.00
213209	Нэг удаагийн тэтгэмж шагнал урамшуулал	22,359,368.00	3,210,000.00
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II)	8,804,743.90	2,206,814.36
	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	-	-
5	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (V)	2,067,600.00	525,000.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	2,067,600.00	525,000.00
2200	Дотоод эх үүсвэрээр	2,067,600.00	525,000.00
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	2,067,600.00	525,000.00
6	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VI)=(IV)-(V)	(2,067,600.00)	(525,000.00)
	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	-	-
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	6,737,143.90	1,681,814.36
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	6,737,143.90
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	6,737,143.90	4,179,458.26

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

/төгрөгөөр /					
Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
C08	2022 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	24948500.00	8185940.00	127386412.70	160520852.70
D01	2023 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	24948500.00	8185940.00	127386412.70	160520852.70
D02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	-	3093551.00	3093551.00
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	24948500.00	8185940.00	130479963.70	163614403.70
D04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт	-	-3093551.00	0.00	-3093551.00
D05	Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт	-	-	-	-
D06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	-	-	-	-
D07	Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү	-	-	-	-
D08	Тайлант үеийн үр дүн	0	0	-14810067.77	-14810067.77
D09	2023 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	24948500.00	5092389.00	115669895.93	145710784.93

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Код	ҮЗҮҮЛЭЛТ	ТӨЛӨВЛӨГӨӨ	ГҮЙЦЭТГЭЛ	Зөрүү	Хувь
1	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	6,737,143.90	(6,737,143.90)	-
2	I. НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	494,244,100.00	495,514,332.12	(1,270,232.12)	100.26
21	УРСГАЛ ЗАРДЛЫН ДҮН	494,244,100.00	495,514,332.12	(1,270,232.12)	100.26
210	Бараа, үйлчилгээний зардал	490,744,100.00	492,304,332.12	(1,560,232.12)	100.32
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	375,100,000.00	374,907,607.29	192,392.71	99.95
210101	Үндсэн цалин	375,100,000.00	374,907,607.29	192,392.71	99.95
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	47,479,000.00	47,172,243.60	306,756.40	99.35
210201	Тэтгэврийн даатгал	32,945,000.00	32,935,657.67	9,342.33	99.97
210202	Тэтгэмжийн даатгал	4,650,000.00	4,640,936.40	9,063.60	99.81
210203	ҮОМШӨ ний даатгал	2,874,000.00	2,784,490.07	89,509.93	96.89
210204	Ажилгүйдлийн даатгал	910,000.00	810,438.35	99,561.65	89.06
210205	Эрүүл мэндийн даатгал	6,100,000.00	6,000,721.11	99,278.89	98.37
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	18,106,100.00	18,070,013.33	36,086.67	99.80
210301	Гэрэл цахилгаан	8,466,100.00	8,466,055.33	44.67	100.00
210302	Түлш, халаалт	6,300,000.00	6,277,338.00	22,662.00	99.64
210303	Цэвэр, бохир ус	3,340,000.00	3,326,620.00	13,380.00	99.60
2104	Хангамж, бараа материалын зардал	20,373,000.00	25,095,255.00	(4,722,255.00)	123.18
210401	Бичиг хэрэг	1,753,000.00	1,752,850.00	150.00	99.99
210402	Тээвэр (шатахуун)	2,530,000.00	2,523,000.00	7,000.00	99.72
210403	Шуудан холбоо, интернэтийн төлбөр	350,000.00	3,528,850.00	(3,178,850.00)	1,008.24
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	740,000.00	740,000.00	-	100.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, аж ахуйн эд зүйлс	15,000,000.00	16,550,555.00	(1,550,555.00)	110.34
2105	Нормативт зардал	18,500,000.00	18,161,279.90	338,720.10	98.17
210501	Эм бэлдмэл, эмнэлэгийн хэрэгсэл	15,000,000.00	14,756,279.90	243,720.10	98.38
210503	Нормын хувцас зөөлөн эдлэл	3,500,000.00	3,405,000.00	95,000.00	97.29
2106	Эд хогшил худалдан авах	6,590,000.00	4,157,900.00	2,432,100.00	63.09
210601	Багаж, техник, хэрэгсэл	2,290,000.00	-	2,290,000.00	-
210602	Тавилга	600,000.00	525,000.00	75,000.00	87.50
210604	Урсгал засвар	3,700,000.00	3,632,900.00	67,100.00	98.19
2107	Томилолт, зочны зардал	880,000.00	897,000.00	(17,000.00)	101.93
210702	Дотоод албан томилолт	880,000.00	897,000.00	(17,000.00)	101.93
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр	3,716,000.00	3,843,033.00	(127,033.00)	103.42

210801	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	3,500,000.00	3,628,437.00	(128,437.00)	103.67
210803	Даатгалын үйлчилгээ	148,500.00	148,500.00	-	100.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	33,750.00	32,346.00	1,404.00	95.84
210805	Тээврийн хэрэгслийн оношилгоо	8,000.00	8,000.00	-	100.00
210806	Мэдээллийн технологийн зардал	25,750.00	-	25,750.00	-
210807	Газрын төлбөр	-	25,750.00	(25,750.00)	-
	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	3,500,000.00	3,210,000.00	290,000.00	91.71
2132	Бусад урсгал шилжүүлэг	3,500,000.00	3,210,000.00	290,000.00	91.71
213209	Нэг удаагийн тэтгэмж урамшуулал	3,500,000.00	3,210,000.00	290,000.00	91.71
	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	494,244,100.00	497,196,146.48	(2,952,046.48)	100.60
1340	Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих	494,244,100.00	497,196,146.48	(2,952,046.48)	100.60
134001	Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих	494,244,100.00	486,346,146.48	7,897,953.52	98.40
134002	Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих	-	10,850,000.00	(10,850,000.00)	-
4	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	6,737,143.90	(6,737,143.90)	-
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	4,179,458.26	(4,179,458.26)	-
6	ТӨСВИЙН БУСАД МЭДЭЭЛЛИЙН АНГИЛАЛ	-	-	-	-
61	БАЙГУУЛЛАГЫН ТОО	-	-	-	-
62	АЖИЛЛАГСДЫН ТОО	17.00	17.00	-	100.00
620001	Удирдах ажилтан	1.00	1.00	-	100.00
620002	Гүйцэтгэх ажилтан	11.00	11.00	-	100.00
620003	Үйлчлэх ажилтан	5.00	5.00	-	100.00

3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа

Сэлэнгэ аймгийн Сүхбаатар сумын Эмнэх-баг өрхийн эрүүл мэндийн төв *Ицаашид ӨЭМТ гэх* нь “Бүртгэгдсэн хүн амын эрүүл мэндийн эрэлт хэрэгцээнд тулгуурлан анхан шатны тусламж, үйлчилгээ болон үндсэн мэргэшлийн нэн шаардлагатай зарим тусламж, үйлчилгээг иргэнд тэгш хүртээмжтэй, тасралтгүй, чанартай, цогц байдлаар үзүүлнэ” гэсэн зорилгын хүрээнд үйл ажиллагаа явуулж байна.

Өрхийн эрүүл мэндийн төвийн үйл ажиллагааны чиглэлийг дараах байдлаар тодорхойлж, хэрэгжүүлэн ажиллаж байна. Үүнд:

- Тусламж, үйлчилгээ авахаар ирсэн хүн бүрт үйлчлэх,
- Нотолгоонд тулгуурласан тусламж, үйлчилгээг үзүүлэх,
- Нийгмийн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээг тэргүүлэх чиглэл болгох,
- Иргэн бүрт эрүүл мэндийн тусламж, үйлчилгээг жигд хүртээмжтэй, чанартай, аюулгүй, чирэгдэлгүй, тасралтгүй үзүүлэх
- Тусламж үйлчилгээг эрүүл мэндийн байдалд үнэлгээ өгөх, оношлох, эмчлэх, сувилах, өвчнөөс урьдчилан сэргийлэх, хянах, эрүүл мэндийг дэмжих, сэргээн засах, хөнгөвчлөх гэх мэт хүрээний дагуу үзүүлнэ.

3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд дараах өөрчлөлтүүд орсон байна. Үүнд:

- *Хөдөлмөрийн тухай хуульд 2023 оны 07 дугаар сарын 07-нд нэмэлт өөрчлөлт орсон,*
- *Засгийн газрын 2023 оны 06 сарын 21 өдрийн 241 дугаар тогтоолоор Төрийн албаны зарим албан тушаалын цалингийн сүлжээ, доод хэмжээг шинэчлэн тогтоосон.*
- *2023 оны 06 дугаар сарын 28-ны ЭМДҮЗ-ийн 6 дугаар тогтоолоор “Төлбөрийн хэмжээ, төлбөрийн арга, журам”-ыг шинэчлэн баталсан,*
- *2023 оны 06 дугаар сарын 28-ны ЭМДҮЗ-ийн 7 дугаар тогтоолоор анхан шатны эрүүл мэндийн байгууллагуудтай “Эрүүл мэндийн анхан шатны тусламж, үйлчилгээ худалдан авах гэрээ”-нд нэмэлт өөрчлөлт оруулсан гэх мэт.*

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж буй дотоод хяналтаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилтийн үр нөлөө сул гэж үзлээ.

Эмнэх-баг өрхийн эрүүл мэндийн төв нь ЭМДЕГ-тай байгуулсан гэрээний дагуу нэг иргэний нормативаар тооцож олгох санхүүжилт, тусламж үйлчилгээний

санхүүжилт зэрэг гүйцэтгэлийн санхүүжилтээр эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжиж байна.

Гэвч төсвөөс олгож буй гүйцэтгэлийн үнэлгээний санхүүжилтийн зарцуулалт, үр дүн, байгууллагын үйл ажиллагаанд аймгийн Засаг дарга, Эрүүл мэндийн газраас хэрэгжилтийг дүгнэж, хяналтыг хэрэгжүүлээгүй байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Өрхийн эрүүл мэндийн төвийн 2023 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

Өрхийн эрүүл мэндийн төвийн 2023 оны санхүүгийн тайланг Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаалаар баталсан “Төсөвт байгууллагад мөрдөх нягтлан бодох бүртгэлийн дансны заавар”-ын дагуу бэлтгэсэн байна.

Тайлант хугацаанд нягтлан бодох бүртгэлийн бодлогод өөрчлөлт ороогүй байна.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангийн нийт хөрөнгө 145,710.7 мянган төгрөг болж, өмнөх оноос 14,810.1 мянган төгрөгөөр буурсан байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/мянган төгрөгөөр/			
Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	6,737.1	4,179.4	-2,557.7
Авлага		12,649.7	12,649.7
Бараа материал	52,915.5	38,727.9	-14,187.6
Үндсэн хөрөнгө	100,868.1	90,153.6	-10,714.5
Нийт хөрөнгө	160,520.8	145,710.7	-14,810.1
Өр төлбөр	0	0	0
Засгийн газрын хувь оролцоо /Эздийн өмч/	160,520.8	145,710.7	-14,810.1
Өр төлбөр ба цэвэр хөрөнгө	160,520.8	145,710.7	-14,810.1

Эх сурвалж: ӨЭМТ-ийн 2023 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан.

Дээрх хүснэгтээс харахад дараах дансанд нөлөө бүхий өөрчлөлт гарсан байна. Үүнд:

- Мөнгөн хөрөнгө данс 4,179.4 мянган төгрөг болж 2,557.7 мянган төгрөгөөр буурсан нь оны эхний дансны үлдэгдлээс зарцуулснаас шалтгаалсан байна.
- Авлага дансанд ЭМДС-аас авах санхүүжилтийн 12,649.7 мянган төгрөгийн авлага тайлагнагдсан байна.
- Бараа материалын дансны үлдэгдэл 38,727.9 мянган төгрөг болж 14,187.6 мянган төгрөгөөр буурсан нь оны эхний үлдэгдлээс зарцуулсантай холбоотой байна.
- Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 90,153.6 мянган төгрөг болж 10,714.5 мянган төгрөгөөр буурсан нь Эрүүл мэндийн яамнаас 13,134.5 мянган төгрөгийн тоног төхөөрөмжийг хүлээн авсан, өөрийн хөрөнгөөр 525.0 мянган төгрөгийн хөрөнгө худалдан авсан болон аймгийн ИТХ-ын 2023 оны 7 дугаар сарын 26-ны өдрийн 123 дугаар тогтоолоор 67,171.1 мянган төгрөгийн хөрөнгийг акталж данснаас хасаж, 24,374.0 мянган төгрөгийн элэгдлийг нэмж байгуулснаас голлон нөлөөлсөн байна.

3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.5.1 Төсвийн төлөвлөлт

Тус байгууллага нь 2023 оны төсөвт зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг 1 хөтөлбөр 1 арга хэмжээгээр тооцон ЭМДС-аас нэг иргэний нормативт санхүүжилтээр 504,245.6 мянган төгрөг төвлөрүүлэхээр төлөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Сэлэнгэ аймгийн ЭМГ-аас тус эрүүл мэндийн төвийн ЭМДС-аас төвлөрөх санхүүжилтийг **494,244.1** мянган төгрөгөөр хянаж баталгаажуулсан байна.

Гүйцэтгэлээр ЭМДС-ийн нэг иргэнээр тооцож олгох санхүүжилтээр 486,366.1 мянган төгрөг, эмчилгээ үйлчилгээний санхүүжилтээр 10,850.0 мянган төгрөг зэрэг 2 арга хэмжээний нийт **497,196.1** мянган төгрөгийн санхүүжилтийг төвлөрүүлсэн байна.

3.5.2 Төсвийн гүйцэтгэл

Төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 1 хөтөлбөрийн 2 арга хэмжээний урсгал үйл ажиллагаанд **495,514.3** мянган төгрөгийг зарцуулж, 100.3 хувийн гүйцэтгэлтэй тайлагнагдсан байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл **495,514.3** мянган төгрөг буюу 100.3 хувьтай тайлагнагдсан нь тайлант онд төлөвлөгдөөгүй шинэ тусламж үйлчилгээний 1

хөтөлбөр нэмэгдэж 10,850.0 мянган төгрөгийн санхүүжилт төвлөрүүлж, 3,178.9 мянган төгрөгийн интернэтийн төлбөрийг төлсөнтэй холбоотой байна.

Хүснэгт 2. Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл

					/мянган төгрөгөөр/	
д/д	Хөтөлбөр, арга хэмжээ	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Биелэлт	
1	Нэг иргэнд ноогдох норматив	494,244.1	492,335.4	-1,908.7	99.5	
2	Тусламж үйлчилгээний зардал		3,178.9	3,178.9		
	Дүн	494,244.1	495,514.3	1,270.2	100.3	

Эх сурвалж: ӨЭМТ-ийн 2023 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

4. АУДИТЫН ТАЙЛАН

4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана” гэж заасны дагуу Эмнэх-баг өрхийн эрүүл мэндийн төвийн 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийгдэх байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Мөн эм, тариурын анхан шатны баримтыг бүрдүүлэн зарцуулж, бүртгэл тайланд тусгаж байх, Шилэн дансны тухай хууль болон ТБОНӨХБАҮХА тухай хуулийг хэрэгжүүлэн ажиллах зөвлөмжүүдийг тусгасан болно.

Аудитыг Сэлэнгэ аймаг дахь Төрийн аудитын газрын аудитор Д.Чулуунцэцэг гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер Б.Батмөнх, дарга, тэргүүлэх аудитор Ч.Энхтуяа нар тус тус хэрэгжүүлсэн.

Эмнэх-баг өрхийн эрүүл мэндийн төвийн 2023 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг Сэлэнгэ аймаг дахь Төрийн аудитын газарт 2024 оны 01 дүгээр сарын 25-ны өдрийн 08 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

4.2 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг “дунд” гэж үнэллээ.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2022 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлын 735,009.9 мянган төгрөгөөс 1.5 хувиар буюу 11,025.1 мянган төгрөгөөр тогтоосныг аудитын явцад дахин хянаж, шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

4.3 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

4.3.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Тайлант хугацаанд өрхийн эрүүл мэндийн төвийн мэдээлбэл зохих 1 төрлийн 4 мэдээллээс 3 мэдээллийг хугацаа хоцроож мэдээлсэн байна.

Энэ нь нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь Шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцээгүй байна гэж дүгнэлээ.

Шийдвэрлэсэн нь: Шилэн дансны тухай хуулийг хэрэгжүүлэн зөвлөмж хүргүүлэв.

4.3.2 Бусад хууль тогтоомжийн хэрэгжилттэй холбоотой

2. Шилэн дансны хуультай холбоотой асуудал

2.1 Илрүүлэлт: Тайлант хугацаанд өрхийн эрүүл мэндийн төвийн мэдээлбэл зохих 1 төрлийн 4 мэдээллээс 3 мэдээллийг хугацаа хоцроож мэдээлсэн байна.

Энэ нь Шилэн дансны тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.1 дэх “Мэдээлэл үнэн зөв, бодитой, иж бүрэн байх”, 4.1.3 дахь “Тогтоосон хугацаанд тогтмол шуурхай оруулж байх” гэсэн заалтууд болон мөн хуулийн 6 дугаар зүйлийг тус тус зөрчсөн байна.

2.2 Өгсөн зөвлөмж: Шилэн дансны мэдээллийг цахим системд хугацаанд нь бүрэн байршуулах.

4.4 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

4.4.1 Завсрын аудитын талаар

Сэлэнгэ аймаг дахь Төрийн аудитын газрын дарга, тэргүүлэх аудиторын 2023 оны 10 дугаар сарын 26-ны 123 дугаар “Санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд аудит хийх тухай” албан бичгийг хүргүүлсэн бөгөөд тус байгууллагын 2023 оны 2 дугаар улирлын санхүүгийн тайланд хийсэн завсрын үеийн санхүүгийн тайлангийн аудитаар алдаа, зөрчил илрээгүй байна.

4.4.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Өмнөх санхүүгийн тайлангийн аудитаар үе шатны ажлыг хэсэгчлэн хийх буюу түүвэрт хамруулан аудитыг гүйцэтгэсэн байна. Аудитаар ямар нэгэн алдаа, зөрчил илрээгүй байна.

5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 25,354.5 мянган төгрөгийн зөрчил¹ илэрч 10,598.2 мянган төгрөгийн зөрчилд албан шаардлага хүргүүлэн, 14,756.2 мянган төгрөгийн алдаа зөрчлийг арилгаж, давтан гаргахгүй байх 1 зөрчилд зөвлөмж өгөв.

5.1 Албан шаардлага

1. Өмнөх санхүүгийн тайланд өглөгөөр тусгаж тайлагнаагүй 2022 оны 4 дүгээр улирлын урамшууллын 7,580.0 мянган төгрөгийг онд олгож зардлаар бүртгэж тайлагнасан нь Төсвийн тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1 дэх “Төсвийн жил нь тухайн оны 1 дүгээр сарын 01-ний өдрөөс эхэлж, тухайн оны 12 дугаар сарын 31-ний өдөр дуусгавар болно”, 7.3 дахь “Төсвийг нэг жилээр баталж, тайлагнах бөгөөд батлагдсан төсвийг сар, улирлаар хуваарилан хэрэгжилтийг зохион байгуулна” гэсэн заалтуудыг тус тус зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Тухайн оны батлагдсан төсвөөр өмнөх оны санхүүгийн тайланд өр төлбөрөөр тайлагнагдаагүй зардлыг санхүүжүүлэхгүй байх албан шаардлага хүргүүлэв.

2. Эмч, сувилагчдын баярыг тохиолдуулан эмч, ажилтнуудыг үндсэн цалингийн 20 хувиар буюу нийт 3,018.2 мянган төгрөгийн урамшууллыг улирлын үр дүнгийн мөнгөн урамшуулалтай давхардуулан олгосон нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1 дэх “Төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах” гэсэн заалтыг зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Төсвийн үр ашигтай, арвилан хэмнэлттэй байх зарчмыг баримтлан, урамшууллыг давхардуулан олгохгүй байх албан шаардлага хүргүүлэв.

¹ Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

3. Засгийн газрын 2023 оны 06 дугаар сарын 21-ний өдрийн 241 дүгээр тогтоолын дагуу 2023 оны 07 дугаар сарын 01-ний өдрөөс эхлэн эмч, ажилтнуудын цалинг шинэчлэн батлагдсан эрүүл мэндийн салбарын төрийн үйлчилгээний албан тушаалын цалингийн сүлжээг үндэслэн шинэчлэн тогтоож, олгоогүй байна. Энэ нь Засгийн газрын 2023 оны 06 дугаар сарын 21-ний өдрийн “Төрийн албаны зарим албан тушаалын цалингийн хэмжээ, доод хэмжээг шинэчлэн тогтоох тухай” 241 дүгээр тогтоолын 6 дугаар хавсралтыг зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Цалинг шинэчлэн баталсан цалингийн сүлжээг үндэслэн тогтоох албан шаардлага хүргүүлэв.

5.2 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1. Анхан шатны баримт болон нягтлан бодох бүртгэлтэй холбоотой асуудал

1.1 Илрүүлэлт: Эм, эмнэлгийн хэрэгслийн 14,756.2 мянган төгрөгийн зарцуулалтын ажил гүйлгээг гүйцэтгэхдээ эмийн захиалгын хуудас, хэрэглэсэн эм тарианы зарлагын хуудас, хатгалт хийсэн тэмдэглэл зэрэг анхан шатны баримтыг бүрэн бүрдүүлэлгүйгээр зөвхөн шаардах хуудас үндэслэн бүртгэл тайланд тусгасан байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1 дэх “Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно”, 13.7 дахь “Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно” гэж заасантай нийцэхгүй байна.

1.2 Өгсөн зөвлөмж: Анхан шатны баримтыг бүрэн бүрдүүлж ажил гүйлгээг гүйцэтгэн, бүртгэл тайланд тусган ажиллах.

Дээрх зөвлөмжийн мөрөөр авч хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг Төрийн аудитын тухай хуулийн 20.5² дахь заалтад тусгасны дагуу аудитын тайланг хүлээн авснаас хойш 30 хоногийн дотор, биелэлтийг 2024 оны 06 дүгээр сарын 15-ны өдрийн дотор тус тус төрийн аудитын байгууллагад ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

² Шалгагдагч этгээд болон холбогдох бусад албан тушаалтан нь энэ хуулийн 20.2-т заасан зөвлөмжийн мөрөөр авч хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг аудитын тайланг хүлээн авснаас хойш 30 хоногийн дотор төрийн аудитын байгууллагад ирүүлнэ.

6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс				Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Дүн												

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Өмнөх онд өглөгөөр тусгаж тайлагнаагүй зардлыг тайлант оны төсвөөс санхүүжүүлсэн	1	7,580.0	1	7,580.0								
Урамшуулал давхардуулан олгосон	1	3,018.2	1	3,018.2								
Анхан шатны баримтын бүрдэл дутуу ажил гүйлгээг гүйцэтгэж бүртгэл тайланд тусгасан.	1	14,756.2					1	14,756.2				
Засгийн газрын 241 дүгээр тогтоолын дагуу цалинг шинэчлэн тогтоогоогүй	1		1									
Дүн	4	25,354.4	3	10,598.2	1	14,756.2	1	14,756.2				

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил	1							
Шилэн дансанд мэдээлбэл зохих 4 мэдээллээс 3 мэдээллийг хугацаа хоцроож мэдээлсэн.	1						1	
Дүн	1						1	
Бусад хууль тогтоомжтой холбоотой зөрчил								
Дүн								
Нийт дүн	1						1	